

БАТЛАВ
СУРГАЛТЫН МЕНЕЖЕР Б. ЭНХБОЛОР

10 ДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

Хугацаа: 80 минут

А хувилбар

Нийт оноо- 40

Нас... Нас... Нас...

/эсээ/

Саяхан надад ахимаг насны эмэгтэй жүжигчин “нас бол ердөө тоо” гэж хэлсэн юм. Бодоод л байлаа. Нас үнэхээр тоо, тоо, тоо... өөртөө шууд л итгүүлэхийг хүслээ. Гэвч таван настай жаахан охин минь төрсөн өдрөө дөхөхөөр хоног тоолдог шиг сүүлийн үед би ялгаагүй тийм болжээ. Чухам цаад учрыг нь сайн мэдэхгүй ч нэг нас нэмэх тоолонд дотроос минь хэн нэгэн өөдгүй этгээд “чи юу хийж амжуулав” хэмээн нэхэл хатуухан асуух болов. Эргэлзэж эхэллээ. Зарим хүмүүсийнхээр нас ердөө тоо л юм бол яагаад би шөнө нойр муутай бол маргааш нь тархи өдөржин дүйнгэ оргих болов. Өмнө нь хоёр өдрийн нойрыг огт тоодоггүй сэн. Үнэхээр зарим хүмүүсийнхээр нас ердөө ТОО юм бол яагаад миний шанаанд буурал үс нэмэгдэж, хөл гар өдрийн алхаандаа түүртэж өвдөг булчин халуу оргиод байх болов. Тэгэхээр биологийн амьдралын хувьд нас зүгээр хэдэн ТОО биш байх нь. Оюун санааны амьдралын хувьд өөр байж болох юм гэж найдах сэтгэл төрнө.

Харин ямар хүмүүс насыг зүгээр тоо гэж боддог вэ? Магадгүй ямар ч зорилгогүй явсан он жилүүдээ мартаж гэж ирээдүйд хийж бүтээх найдлага бий гэдэгт итгэж явдаг гэнэн хүмүүсийн бодол биз. Үгүй бол нэгэнт юу ч хийж бүтээж чадахгүй гэдгээ мэдчихээд өөрсдийгөө хуурах гэсэн харамсмаар оролдлого байхыг үгүйсгэхгүй. Нэг танил зохиолч минь 50 нас хүрээд хамгийн гол бүтээлээ бичнэ гэдэг юм. Тэр нь яруу найргийн бүтээл байх юм гэнэ лээ. Мэдээж хувь тавилан байвал түүний энэ мөрөөдөл биелнэ. Харин... дахиад л би өөрөө ч мэдэлгүй учир битүүлэг гурван цэг хаяж орхилоо. 50 нас оюун санааны байнгын бэлтгэл хийдэггүй, таван жилд яруу найргийн ганцхан жижиг ном хэвлүүлдэг ЗОХИОЛЧИД идэвхтэй оюуны амьдралын хувьд даанч өндөр нас. Тиймээс л би бүх эргэлзээ тээнэглзлээ гурван цэгэнд багтааж орхилоо.

Хэрэв хонин арц шиг 2000 жил, үгүй ядаж яст мэлхий 300 орчим жил насалдаг бол хүнд 50 жил хүүхэд нас л даа? Гэтэл харамсалтай нь тийм биш. Тэр тусмаа Монголд. Ар Кавказын ч юм уу Хятад, Афганистан хоёрын хил дээр оршдог уулын нэг тосгоныхон шиг 100 насалдаг бол бас асуудал өөр л дөө? Тэнд мэдээж цаг уурын таатай сайхан нөхцөл байдаг нь тодорхой. Уулын тунгалаг агаар. Харин энд бол миний хотын гоё саарал утаа, нүргээн, атаархал жөтөөрхлийн мананцар, уур бухимдал. Товчхондоо гадаад хэлний гайхамшигтай үг болох СТРЕСС ноёлно.

Дахиад л нас... нас... нас.. гэсэн дарамттай үг тархин дотор минь үүрлэж, үл тайлагдах хүнд бодлууд зууралдана. Өнөөх өөдгүй этгээд сар өдрүүд хорогдох тусам ”юу хийж амжуулав” хэмээн ам асууна. Тэгээд л түүнд хариулах юмтай байх гэсэн мэт чухам юунд шахагдаж хөөгдөөд байгаагаа мэдэхгүй тархи толгойгоо гашилган зүгээр суухгүйг хичээнэ.

Зохиолчид ихэвчлэн чононд ээрэгдэж хөөгдсөн хонь мэт амьдрах үйлд унасан байдаг. Яах гэж өдөрт гуравхан цаг унтаж, яах гэж амрах завгүй цаас цоохорлож, яах гэж бусдын өмнөөс энэлэн шанална вэ? Энэ асуултад минь ханатал хариулах хүн одоохондоо миний амьдралд учраагүй л явна.

Шилэн дэлгүүрийн толин хананд алхаж яваагаа харахад хэдийнээ би ялимгүй бөгтийжээ. Харин оюун санааны хувьд...

1. Эхийг уншаад тодруулсан хэсгээс ургуулан, тайлбарламж бичнэ үү. Үгийн тоо 100-120, 10 оноо

- 2. “Зохиолчид ихэвчлэн чононд ээрэгдэж хөөгдсөн хонь мэт амьдрах үйлд унасан байдаг” өгүүлбэрийг гишүүдээр ялган зурж, бүтцээр тодорхойлоорой. 4 оноо
- 3. Дараах холбох хэрэглүүрийн утга, үүргийг тодорхойлон бич.
 - А. “Харин ямар хүмүүс насыг зүгээр тоо гэж боддог вэ?”-
 - Б. “Тэр тусмаа Монголд. Ар Кавказын ч юм уу Хятад, Афганистан хоёрын хил дээр оршдог уулын нэг тосгоныхон шиг...”-
 - В. “Гэтэл харамсалтай нь тийм биш.”-

Г. Тиймээс л би бүх эргэлзээ тээнэглэлээ гурван цэгэнд багтааж орхилоо. -

4. Бусдаар үйлдүүлэх хэвийн дагавартай үгийг олж, үгийн бүтцээр задлан тайлбарла. 4 оноо

5. Үйл үг бүтээх -л дагавар залгахад бусдаасаа өөр бичигдэх үгийг ол.

А. Ах-л Б. Нас- л В. Идэш- л Г. Уут- л

6. Бүтээвэр залгахад гийгүүлэгч нэмэгдэх үгийг ол.

А. Гадарга- ын Б. Тайлан- ын В. Зураг- ийн Г. Сайн- ы

7. Д. Намсрайн “Жамухын өчил” зохиолын аль нэг дүрийг сонгон хэлсэн үг, хийсэн үйлдлээс нь зан төрхийг дүгнэн бичээрэй. Үгийн тоо 30-40, 5 оноо

8. Дараах морины дүрслэл аль зохиолын хэсэг вэ? 2 оноо

...Ташаа нь тэвхийж, хавирганы яс нь зурайсан ялгуун саарал морь нь тогтож ядан, гуа сайхан дөрвөн хөлөөрөө ээлжлэн газар цавчилж...

А. Бодончар Богд Б. Хөдөө талын үзэсгэлэн В. Хуучин хүү Г. Жамухын өчил

9. ... Эсэргэн хавар цагийн дохио ирэхэд

Эгшиглэн донгодогч олон шувуу жиргэлдэн

Ээлжлэх цагийн эргэлтийг мартаад

Эгүүрд байгаа хэлбэртэй байдаг лгэсэн хэсэг хэний шүлэг вэ?

А. Д. Равжаа “Дөрвөн улирал” Б. Д. Нацагдорж “Дөрвөн цаг” В. Д. Нямсүрэн “Дөрвөн цаг”

10. Үндэсний бичгээс уншаад, кирилл бичигт хөрвүүлээрэй. [5 оноо]

ᠨᠢᠯᠢᠭᠤ ᠬᠡᠭᠡᠨ ᠲᠡᠭᠦᠨ
 : ᠰᠢᠨᠰᠡᠭᠡᠨ ᠲᠡᠭᠦᠨ
 ᠨᠢᠯᠢᠭᠤ ᠬᠡᠭᠡᠨ ᠲᠡᠭᠦᠨ ᠬᠡᠭᠡᠨ
 ᠰᠢᠨᠰᠡᠭᠡᠨ ᠲᠡᠭᠦᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠲᠡᠭᠦᠨ
 ᠲᠡᠭᠦᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠲᠡᠭᠦᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠲᠡᠭᠦᠨ
 ᠲᠡᠭᠦᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠲᠡᠭᠦᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠲᠡᠭᠦᠨ
 ᠲᠡᠭᠦᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠲᠡᠭᠦᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠲᠡᠭᠦᠨ
 ᠲᠡᠭᠦᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠲᠡᠭᠦᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠲᠡᠭᠦᠨ

.....

БАТЛАВ
Б. ЭНХБОЛОР

СУРГАЛТЫН МЕНЕЖЕР
10 ДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

Хугацаа: 80 минут

Б хувилбар

Нийт оноо- 40

ШАТ

/эсээ/

Олон ч шатаар өгсөж уруудаж дээ? Тоог нь гаргах аргагүй болжээ. Цор ганцаараа баяр хөөртэй, уйтгар гунигтай эсвэл найз нөхөдтэйгээ, хань ижилтэйгээ, үр хүүхэдтэйгээ, шавь нар дүү нартайгаа, аав ээж, ах дүүстэйгээ хамт шатаар бишгүй л уруудаж, бишгүй л өгсөж. Тэр тоолонд арван хэдэн насны нэгэн дурсамж байнга сөхөгдөнө.

Анх намайг төрөхөд л гэрийнхэн маань МОМО гэж нэрлэсэн гэдэг юм. Сүүлд эмээ монхор бор юм төрөхөөр нь өхөөрдөөд ингэж дуудацгаасан гэж билээ. Бараг л сургуульд ортлоо өөрийнхөө албан ёсны нэр БАТХУЯГ гэдгийг мэддэггүй байлаа. Заримдаа ирц бүртгээд багш нэр дуудахад “Батхуяг гэдэг чинь хэн билээ” гэж бодож суусан удаатай. Одоо ч найз нөхөд, их л дотны хүмүүс минь, хайртай дүү нар бүгд МОМО гэж дууддаг. Энэ нэрэндээ ч би дуртай. Харин өнөөх байнга сөхөгддөг дурсамж минь ийм учиртай.

Дунд сургуулийн долдугаар ангийн сурагч байхдаа МОМО нэртэй дэлхийн түүхэнд тодорсон суут хүн байдаг эсэхийг хайж билээ. Нэлээд хугацаанд хайсан боловч олоогүй юм. Их л сэтгэлээр унасан санагдана. Аргаа бараад дунд сургуулийн түүхийн багшаасаа асуусан юм даг. Харин багш орос хэлээр нэвтэрхий толь шүүрдэж шүүрдэж МОМО ГИУЗЕППЕ гэдэг итали эр дэлхийд нэртэй уран барималч байдаг юм байна гэсэн баяртай мэдээ дуулгав. Хожим тэр итали эр 1932 онд Италийн Ватиканы музейн дэлхийд хосгүйд тооцогддог ШАТ-ыг хийсэн гэдгийг мэдэж авсан юм. Тэгээд олон хоног ер бусын гайхамшигтай ШАТ хийх мөрөөдөлд автав. Тэр Италиас лав би илүү шат хийнэ дээ? Адилхан нэртэй хүн маань алдартай ШАТ хийсэн байхад би ядаж модон шат ч хийгээгүй гэж гутарсан тал ч бий.

Английн хатан хааны ордонд Тупил нэртэй алтан зул цэцгийн шат байдгийг дуулаад үзэхсэн гэж их мөрөөдөж билээ. Зарим шөнө хоосон агаарт үл үзэгдэх шат хийчихээд өгсөж явна гэж зүүдэлсэн санагддаг юм. Ер бусын шат гэхээр тийм л үл бүтэх уран сэтгэмж намайг эзэмдэж байсан ажээ. Агаарт үл үзэгдэх шат хийгээд тэнгэрт хүрэх санаа минь одоо ч хааяа толгойд эргэлддэг гэвэл итгэх хүн ховор биз. Хүүхэд насны гэгээн дурсамж минь одоо ч шатаар өгсөх уруудахад хааяахан бодол дундуур шурган орж ирдэг юм.

Харин энэ хэсэг бол өөр ШАТ-ны тухай эргэцүүлэл. Нэгэн өвгөн багш минь “би чиний утга зохиолын өмнөх шат. Чи над дээр гишгэж өөдөө өгссөн. Би байгаагүй бол чи дээш гарахгүй” гэж загнах занах хоёрын дундуур айлгаж билээ. Манай утга зохиолд ингэж хүндлэл хүлээхийг, хүндлэхийг шаардагсад тийм ч цөөнгүй. Багшийн хэлснээр бол хамгийн аймаар нь би хүн дээр гишгэж дээшээ гарсан болчихоод байлаа. Эсвэл би хүний хормойноос зүүгдээд, дараа нь бэлхүүсээр нь тэврээд, эцэст нь мөрөн дээр нь гараад одоо толгой дээр нь суучихсан юм шиг санагдаад байв. Өвгөн багшийн хэлсэн үгийг үнэн гэж тооцвол би бусдыг хайр найргүй гишгэлж шат өгссөн өөдгүй этгээд болж таарав. Үнэнийг хэлэхэд зарим хүнээр би ном заалгасан минь үнэн ч өөрийн муугаас болж юу ч сураагүй юм. Гэтэл зарим хүнээр би ном заалгаагүй мөртлөө асар их зүйл сурч авсан байгаа юм. Тийм байтал би ном заасан бүгдийг багш гэж дуудаад доогуур харж, дорой царайлж явах ёстой болж таараад байв. Бас болоогүй өмнөх шат гэж хүндлэх ёстой болов. Гэтэл тийм түвшний уран зохиолын ШАТ-уудыг би аль арван хэдэн насандаа гишгэлгүй үсрээд гарчихсан байдаг.

Эцэст нь МУНХРАЛ, ШАТ хоёр ямар холбоотой вэ? гэсэн асуулт л үлдлээ. Хамгийн товчхондоо МУНХРАГЧИД хэзээ ч ШАТ болдоггүй. Тэгэхээр ямар ч холбоогүй...

